



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017.12.25 № 4-2/7252
танай 2017.12.15-ны № 18 -Т

Асуулгын хариу өгөх тухай

Танаас 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн асуулгатай танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Гаалийн тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 1.2, 138 дугаар зүйлийн 1.6-д заасны дагуу татваргүй барааны дэлгүүрийн зөвшөөрлийг Гаалийн удирдах төв байгууллага олгоно гэж заасан байна.

Үүний дагуу Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/162 дугаар тушаалаар Эй Ди Зэт ХХК, Паладинбюлдинг ХХК, Ханбүргэдэй ХХК, Империа дютти фрий ХХК зэрэг компаниудад татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосон байх бөгөөд 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/219 дугаар тушаалаар буцаан хүчингүй болгосон байна. Энэхүү тушаалууд гарснаар тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдэд ямар нэгэн хохирол учраагүй бөгөөд эдгээр аж ахуйн нэгжүүд татвартай холбоотой аливаа зөрчил гаргаагүй, гаалийн тухай хууль, гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журмуудын хүрээнд гаалийн бүрдүүлэлт хийж байсныг зөвшөөрөл авсан байсан компани тус бүрээр дараах байдлаар танилцуулж байна.

1. Ханбүргэдэй ХХК нь гаалийн бүрдүүлэлтийн 740 горим /Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулах/-оор 27,169.20 ам. доллар, 742 горим /Барааг гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах/-оор 6,652.6 ам. долларын, нийт 33,821.88 ам. долларын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулсан боловч үйл ажиллагаа нь эхэлж борлуулалт хийгдээгүй. Татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагааг нь хүчингүй болгосны дараа 2017 оны 12 дугаар сарын 07-нд 456 горим /гаалийн баталгаат бүсээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах/-оор нийт 27,333.9 ам. долларын бараанд гаалийн бүрдүүлэлт хийж 11,851,133.00 төгрөгийн татвар төлсөн. Одоо үлдэгдэл 6,652.6 ам. долларын бараа нь зохих горимд байршихаар гаалийн хяналтад битүүмжлэгдэн хадгалагдаж байна.
2. Империа дютти фрий ХХК нь гаалийн бүрдүүлэлтийн 742 горим /Барааг гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах/-оор нийт 358,251.38 ам. долларын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулсан. Ажиллаж байх хугацаандаа 47,881.00 ам. долларын борлуулалт хийж, борлуулалт хийсэн бараандаа 314 горим /Татваргүй барааны дэлгүүрээс хилийн чанадад буцаан гаргах/-оор 2 удаа гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. Одоо үлдэгдэл 310,370.38 ам. долларын бараа нь зохих горимд байршихаар гаалийн хяналтад битүүмжлэгдэн хадгалагдаж байна.

3. Паладинбюлдинг ХХК нь гаалийн бүрдүүлэлтийн 742 горим /Барааг гаалийн баталгаат агуулахаас татваргүй барааны дэлгүүрт оруулах/-оор нийт 82,049.72 ам. долларын барааг татваргүй барааны дэлгүүрт оруулсан. Ажиллаж байх хугацаандаа 52,189.60 ам. долларын борлуулалт хийж, борлуулалт хийсэн бараандаа 314 горим /Татваргүй барааны дэлгүүрээс хилийн чанадад буцаан гаргах/-оор 2 удаа гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. Одоо үлдэгдэл 29,860.60 ам. долларын бараа нь зохих горимд байршихаар гаалийн хяналтад битүүмжлэгдэн хадгалагдаж байна.
4. Эй Ди Зэт ХХК нь өнгөрсөн хугацаанд ямар ч бүрдүүлэлт хийж, үйл ажиллагаа явуулаагүй байна.

Дээрх аж ахуйн нэгжүүдийн борлуулаагүй үлдэгдэл бараанд Гаалийн тухай хуульд заасны дагуу "Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим хэрэгжүүлэх журам", "Барааг хилийн чанадад буцаан гаргах горим хэрэгжүүлэх журам", "Гаалийн баталгаат агуулахын горим хэрэгжүүлэх журам", "Татваргүй барааны дэлгүүрийн горим хэрэгжүүлэх журам" зэрэг горимуудаас мэдүүлэгч өөрийн хүсэлтээр сонгож гаалийн бүрдүүлэлт хийх боломжтой юм.


Гаалийн тухай хууль, Татваргүй барааны дэлгүүрийн горим хэрэгжүүлэх журамд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барааны хөдөлгөөнийг програмын дагуу өдөр бүр хөтөлж, гаалийн байгууллагад сар бүр мэдээгээ гарган өгч, гаалийн байгууллагаас хариуцсан ажилтан хяналт тавьж ажилладаг учир гаалийн болон бусад татвараас зайлсхийх боломж байхгүй бөгөөд улсад татварын ямар ч хохирол учруулаагүй болно.

Түүнчлэн дээрх компаниуд нь тусгай зөвшөөрлийг цуцалсантай холбоотойгоор ямар нэг гомдол гаргаагүй, дээрх үйл ажиллагаа нь гаалийн тухай хууль, холбогдох журмын хүрээнд хийгдсэн тул улсаас хохирол барагдуулах тухай аливаа асуудал үүсэхгүй гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хэлэлцээр"-ийн хүрээнд тохирсны дагуу татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлогыг хумих, цэгцлэх чиглэлийг баримталж байгаа бөгөөд Сангийн яамны зүгээс харьяа байгууллагуудын үйл ажиллагааг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд засаж сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Цаашдаа гаалийн албаны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төрийн тусгай албан хаагчдын ёс суртахууныг нэмэгдүүлэх, дотоод хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хамтын ажиллагаанд талархсан,



Ч.ХҮРЭЛБААТАР